



**ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар”
ТӨҮГ-ын захирлын 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн
А/62 дугаар тушаалд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.10, “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын дүрмийн 5.5.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын захирлын 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/62 дугаар тушаалаар томилогдсон “Техникийн байнгын комисс”-ыг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Комиссын ахлагч: Үйлчилгээ ашиглалтын хэлтсийн дарга

Гишүүд: Автобаазын дарга
Нягтлан бодогч
Механик


Нарийн бичгийн дарга: Нярав- жолооч

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын захирлын 2022 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/62 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Техникийн байнгын комиссын ажиллах журам”, 2 дугаар хавсралт “Техникийн байнгын комиссын дүгнэлт”, 3 дугаар хавсралт “Автомашин хүлээлцэх акт”-ын загвар тус бүр хэвээр мөрдөгдөнө.

ЗАХИРАЛ

Б.ХАЛИУН





“ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР” ТӨҮГ-ЫН ТЕХНИКИЙН БАЙНГЫН КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй автомашин, хөдлөх бүрэлдэхүүн, тэдгээрийн запас сэлбэг, бензин, шатах тослох материалын зарцуулалт, ашиглалтын технологийн мөрдөлтөд хяналт тавих, гарсан эвдрэл гэмтэл, саатал, доголдлын шалтгааныг тогтоох, техникийн комиссын дүгнэлт үйлдэх, техникийн хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагааг зохицуулна.

Хоёр. Техникийн байнгын комиссын ажиллагаа

- 2.1. Техникийн байнгын комиссын бүрэлдэхүүнийг “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын захирлын тушаалаар томилно.
- 2.2. Техникийн байнгын комисс нь бүрэлдэхүүнийг “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа автомашин, хөдлөх бүрэлдэхүүн, автомашины запас сэлбэг, бензин, шатах тослох материалын зарцуулалт, ашиглалтын технологийн мөрдөлтөд хяналт тавьж, шаардлагатай шинэ сэлбэг солих, хуучин сэлбэг хэрэгслийг хурааж авсан тухай бүр техникийн комиссын дүгнэлт үйлдэж баталгаажуулж ажиллана.
- 2.3. Парк шинэчлэлийн хүрээнд худалдаж авсан болон эзэмшигч солигдож байгаа автомашиныг шинэ эзэмшигчид “Автомашин хүлээлцэх акт” үйлдэн хүлээлгэн өгч, автомашинуудад хувийн хэрэг хөтлөн ажиллана.
- 2.4. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын Автобаазын тээврийн хэрэгсэл, автомашинуудын шатахуун зарцуулалтын жишиг нормыг чанд мөрдөж, өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд Техникийн байнгын комиссын хурлаар хэлэлцэн, байгууллагын удирдлагад танилцуулан тушаал, шийдвэр гаргуулж ажиллана.

Гурав. Техникийн дүгнэлт гаргах, акт тогтоох

- 3.1. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын Автобаазын тээврийн хэрэгсэл, автомашинуудад эвдрэл, гэмтэл, доголдол учирсан тухай бүр техникийн комиссын дүгнэлт үйлдэх ажиллагааг хийнэ.

- 3.2. Ашиглалтын явцад автомашины эд ангид элэгдлийн улмаас үүссэн эвдрэл, гэмтэлтэй холбоотой эзэмшигч жолоочийн мэдүүлэг, фото зураг, видео бичлэг, болон холбогдох нотлох баримтыг комиссын дүгнэлтэд хавсаргана.
- 3.3. Жолоочийн хариуцлага, аваар ослын улмаас автомашины эд ангид эвдрэл, гэмтэл үүссэн тохиолдолд эвдрэлийг тодорхойлж, хохирлын хэмжээг тогтоож, дүгнэлт үйлдэн, буруутай этгээдээр хохирлыг барагдуулах арга хэмжээг авна.
- 3.4. Техникийн байнгын комисс нь техникийн дүгнэлт гаргахдаа нотлох баримтад тулгуурлан шийдвэр гаргана.

Дөрөв. Техникийн байнгын комиссын үүрэг


- 4.1 Техникийн байнгын комисс нь тухайн автомашинд гарсан эвдрэл, гэмтэл, шалтгааныг үнэн зөв тогтоож, үнэлэлт дүгнэлт өгнө.
- 4.2 Автомашины эд ангийг сэргээн засварлах, шинээр солих тохиолдолд Техникийн байнгын комиссын дүгнэлтэд тухайн эд ангийг сэргээн засварлахад шаардлагатай материал, сэлбэг болон хуучин эд ангийг хурааж авсан талаар тэмдэглэнэ.
- 4.3 Автомашинд засвар үйлчилгээ хийх болсон шалтгааны талаар дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж ажиллана.
- 4.4 Техникийн байнгын комиссын дүгнэлтийн мөрөөр авах арга хэмжээг онц яаралтай, яаралтай, энгийн зэрэглэлээр биелэгдэх бодит нөхцөлөөр тогтоож, хариуцах эзэн, гүйцэтгэх хугацаа зэргийг тодорхой зааж баримтад хавсаргана.
- 4.5 Жолоочийн хариуцлагаас үүдсэн Техникийн байнгын комиссын дүгнэлтийн талаар буруутай албан тушаалтанд урьдчилан мэдэгдэнэ.
- 4.6 Техникийн байнгын комисс нь “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын Автобаазын автомашинууд тэдгээрийн резин дугуй, зай хураагуур, эдэлгээний нөөцийн жишиг нормыг батална.
- 4.7 Автомашин, түүний эд ангид гарсан эвдрэл гэмтлийн талаарх техникийн комиссын дүгнэлтийг комиссын гишүүдийн гарын үсгээр баталгаажуулна.
- 4.8 Парк шинэчлэлийн хүрээнд худалдаж авсан болон эзэмшигч солигдож байгаа автомашиныг шинэ эзэмшигчид “Автомашин хүлээлцэх акт” үйлдэн хүлээлгэн өгч, комиссын гишүүдийн гарын үсгээр баталгаажуулна.

Тав. Бусад

- 5.1 Техникийн байнгын комиссын дүгнэлт, комиссын хурлын шийдвэрийг үндэслэн автомашины эд анги солих, урсгал засварт оруулах талаар төлөвлөгөөнд тусгана.
- 5.2 Техникийн байнгын комиссын шийдвэр нь “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын Автобаазын техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна.

- 5.3 Техникийн байнгын комиссын ахлагч ажлын тайлан, хурлын шийдвэрийг “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын захиралд тайлагнан ажиллана.
- 5.4 Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын Захирлын 2025 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 01/30 дугаар тушаалын 02 дугаар хавсралт.



ТЕХНИКИЙН КОМИССЫН ДҮГНЭЛТ

20.. оны .. сарын .. өдөр № Улаанбаатар хот

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын Автобаазын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй улсын дугаартай, автомашиныг
.....нарын бүрэлдэхүүнтэй техникийн комисс жолооч
..... оролцуулан автомашины техникийн байдлыг шалгаж үзлээ.

1. Уг авто машин нь онд ашиглалтад орсон. Автомашины марк
Өнгө,..... Төрөл, Загвар, Нийт гүйлт Спидометрийн
заалт
2. Уг авто машиныг задалж үзэхэд
.....
..... байдлууд илэрлээ.

Комисс тогтоосон нь

1. Уг эвдрэл нь
..... гэж үзлээ.
2. Эвдрэлийн шалтгаан ба хариуцсан эзэн төлбөрийн хэмжээг бич.
.....

ДҮГНЭЛТ ГАРГАСАН

Комиссын ахлагч: Үйлчилгээ ашиглалтын хэлтсийн дарга

Гишүүд: Автобаазын дарга


Нягтлан бодогч

Механик

Нарийн бичгийн дарга: Нярав жолооч

/Дүгнэлтийг зөвшөөрсөн жолооч овог нэр/

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын Захирлын 2025 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн 04/30 дугаар тушаалын 3... дугаар хавсралт



АВТОМАШИН ХҮЛЭЭЛЦЭХ АКТ

20.. оны .. сарын .. өдөр

№

Улаанбаатар хот

1.	Машин хүлээлгэн өгсөн жолооч	
2.	Машин хүлээн авсан жолооч	
3.	Автомашины өнгө	
4.	Автомашины марк	
5.	Автомашины улсын дугаар	
6.	Автомашины арлын дугаар	
7.	Нийт гүйлт /километрээр/	
8.	Толь	Гадна
		Дотор
9.	Гэрэл	Дохио
		Хол, ойрын
		Кабины
		Нэмэгдэл
10.	Хянах самбарын ажиллагаа	
11.	Шил арчигч	Урд
		Хойд
12.	Хөдөлгүүрийн ажиллагаа	
13.	Тормозны ажиллагаа	
14.	Рулийн механизм	
15.	Тусгай тоноглол	Кондейшн
		Чанга яригч
		Маяк
16.	Түлхүүр багаж	
17.	Суудлын бүрээс	
18.	Дугуй	Өвөл
		Зун
		Запас дугуй
19.	Эмийн сан	
20.	Галын хор	
21.	Ослын тэмдэг	
22.	Дугуйн эвүүр	
23.	Автомашины үзэмж /угаасан байх/	
24.	Банкны үлдэгдэл бензин /литрээр/	
25.	Жолоочийн, тээврийн хэрэгслийн даатгал	
26.	Тээврийн хэрэгслийн болон татварын гэрчилгээ	
27.	Торгууль	

АВТОМАШИН ХҮЛЭЭЛЦҮҮЛСЭН КОМИСС:

Гишүүд: Автобаазын дарга
 Диспетчер
 Нягтлан бодогч
 Механик

Нярав жолооч

.....

Хүлээлгэн өгсөн жолооч

.....

Хүлээн авсан жолооч

.....